



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/153

Мандалговь

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
вакцинжуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, Малын Удмын Сан Эрүүл Мэндийг Хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, вакцинжуулалтын хамрагдах малын тоо, вакцины хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Вакцинжуулалтыг 2017 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн зохион байгуулж үр дүнг тайлагнахыг Мал эмнэлэг үржлийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарт даалгасугай.

3.Урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага, мэдээллээр ханган, ажлын явц гүйцэтгэлд хяналт тавихыг Ч.Ганбаатар /Засаг даргын орлогч дарга/, Р.Булгантамир /Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Р.МӨНХТОГТОХ

